

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
3.1	Тооллогын үр дүнгийн талаар.....	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5	Аудитын явцад илүүрлсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
АИХ	Ардын Их Хурлын Тэргүүлэгчид
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/330
танай _____-ны № _____-г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Анагаах ухааны хүрээлэнгийн захирал П.Эрхэмбулган Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэж үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнгийн талаар зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн "Гроут финанс Аудит" ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв.

Анагаах ухааны хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Анагаах ухааны хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Анагаах ухааны хүрээлэнгийн эрхэм зорилго нь:

Анагаахын шинжлэх ухаан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөгжлийн ерөнхий хандлага, өнөөгийн түвшин, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогц нэгдлийг хангасан, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай шилдэг судлаачдаас бүрдсэн Монгол Улсын эмнэл зүйн анагаах ухааны тэргүүлэх эрдэм шинжилгээний байгууллага байна гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагаа:

Анагаах ухааны хүрээлэн нь БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1961 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн зарлигаар Шинжлэх Ухааны Академийн 5 хүрээлэн байгуулсны нэг нь юм. Анагаах ухааны хүрээлэн нь Нийгмийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын сектор, Мэс заслын сектор, Дотор өвчин судлалын сектор, Хүүхэд, эмэгтэйчүүдийн сектор, Хоол судлалын сектор, халдварт өвчин, халдвар судлалын сектор гэсэн 6 секторын бүтэцтэй байгуулагдсан.

Одоо тус байгууллага үндсэн 46 ажиллагсад, үүний дотор гэрээт 22 ажиллагсадтай үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна. Хүрээлэнгийн анхны захирлаар Түндэвийн Шагдарсүрэн ажилласан бөгөөд түүний 80 насны ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит болгож дурсгалыг нь мөнхжүүлсэн түүхтэй. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар

тогтоолоор Т.Шагдарсүрэнгийн нэрэмжит Анагаах ухааны хүрээлэнг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяанд шилжүүлсэн.

Шинжлэх Ухаан технологийн тухай хуулиар Анагаах ухааны хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үндсэн чиг үүрэг нь:

- Анагаах ухааны эрдэм шинжилгээ, сургалт, эмнэл зүйн тусламж үйлчилгээг хослуулан ажиллах,
- Монгол улсын анагаах ухааны хөгжил, эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудалд чиглэсэн эрдэм шинжилгээний төсөл, суурь судалгаа,
- Цөм технологи, инновацийн ажлыг өндөр түвшинд хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх,
- Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжлийн ур чадвар чадавхийг сайжруулах,
- Салбар хоорондын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг байнга дээшлүүлэх.

Зорилго, зорилт, үндсэн чиг үүргээ биелүүлэхэд 6 үндсэн нэгжид анагаах ухааны эрдэмтэн судлаачид 56 жилийн хугацаанд ном, сурах бичиг, гарын авлага, монограф 130 орчим, дууссан ажлын төслийн тайлан 84, шинэ бүтээл 49, шинжлэх ухааны нээлт 2, оновчтой санал, ашигтай загвар 361 гаргаж эрүүл мэндийн салбарт нэвтрүүлсэн байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны төсвийг БСШУСЯ-ны харъяа Шинжлэх ухаан технологийн сангаас олгож байна. Санхүүгийн тайлангаа Шинжлэх ухаан технологийн санд нэгтгүүлдэг. Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллаж байна.

Хүрээлэн нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу төсвийн шууд захирагчийн үүргийг Анагаах ухааны хүрээлэнгийн захирал гүйцэтгэж байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн захирлаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн Б/31 дүгээр тушаалаар П.Эрхэмбулган томилогдон төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Анагаах ухааны хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Шинжлэх Ухаан технологийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Анагаах ухааны хүрээлэн нь БСШУС-ын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримталж байна. Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд уг бодлого нь тухайн байгууллагын онцлог буюу хэд хэдэн тайлангийн хугацаанд хамрагдах эрдэм шинжилгээний ажлын зардал болон түүнтэй холбоотой санхүүжилтийн орлогыг хэрхэн яаж тусгах талаар тодорхой тусгаагүй байна.

Тус хүрээлэнд үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай шилдэг судлаачдаас бүрдсэн Монгол Улсын эмнэл зүйн анагаах ухааны тэргүүлэх эрдэм шинжилгээний ажилтнууд тодорхой төсөл хөтөлбөрүүдийг удаан хугацаагаар хэрэгжүүлж, түүнтэй холбоотой санхүүжилтын орлого болон зардлыг холбогдох тайлант хугацаанд нь үнэн зөв илэрхийлээгүйгээс хүрээлэнгийн санхүүгийн үр дүн бодит байдлаас зөрүүтэй илэрхийлэгдэхэд хүрч байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Анагаах ухааны хүрээлэн нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous ” програм хангамж ашигладаг байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Анагаах ухааны хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үед 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгийн 1 (нэг) хувь буюу 2,569.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцоолж жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгийн 1(нэг) хувь буюу 8,277.9 мянган төгрөг байхаар тооцох нь чанарын хувьд тохирно гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал				/мянган төгрөгөөр/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	-	
2	Албан шаардлага	1	278,631.5	
	Дүн	2	278,631.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Эрдэм шинжилгээний ажлыг удаан хугацааны төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг ба тухайн төсөл хөтөлбөрүүд нь ижил бус тайлант хугацаанд хэрэгжиж, дуусдагтай холбогдуулан санхүүжилтийн орлого зардлыг тайлагнаж бүртгэхгүй нь нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд нийцүүлэхгүй байгаа ба үүнээс шалтгаалж Анагаах ухааны хүрээлэнгийн тайлант оны үр дүн бодит байдлаас зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

Энэхүү байдлыг Анагаах ухааны хүрээлэнгийн удирдлага болон нягтлан бодогч мэдэж байгаа боловч Сангийн яамнаас батлан гаргасан заавар журамтай нийцэхгүй байгаагаас уг асуудлыг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байна.

Анагаах ухааны хүрээлэнд хэрэгжиж байгаа төслүүдээс тайлант онд үр дүн нь гараагүй буюу хэрэгжиж дуусах хугацаа болоогүй байгаа төслийн хувьд түүнтэй холбоотой төсвөөс авсан санхүүжилт болон гарсан зардлыг төслийн хэрэгжиж дуусах хүртэл нь урьдчилж орсон болон урьдчилж гарсан зардалд бүртгэж байгаад төсөл хэрэгжиж дууссан хугацаанд нь санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнах ёстой.

Тус хүрээлэнгийн хувьд хэрэгжиж дуусаагүй буюу дуусаагүй төслийн зардлыг санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн ба түүнтэй холбоотой орсон санхүүжилтийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд урьд оны болон тайлант жилийн санхүүжилтийн орлогоор хүлээн зөвшөөрсөн нь тайлан оны үр дүнг 285,000.0 мянган төгрөгөөр илүү буюу бодит байдлаас зөрүүтэй илэрхийлэхэд хүргэсэн байна.

Төсөвт байгууллагын дээд шатны төсвийн захирагчдаас татаас санхүүжилтыг түүнийг гүйцэтгэлийн хэрэгжих хугацааг үл харгалзан тухайн тайлант жилийн санхүүжилтын орлогоор бүртгэж тайлагнахыг Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалаар зохицуулсан байна.

Анагаах ухааны хүрээлэнгийн удирдлагын зүгээс уг гүйлгээг санхүүгийн тайланд залруулах боломжгүй байгаа ба энэхүү тайлагналын зөрүүтэй байдлыг бид тус байгууллагын алдаа зөрчилтэй асуудал гэж үзэхээс илүү салбарын төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд шийдвэрлэж зохицуулах шаардлагатай гэж үзлээ.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

"Үс арчилгаа, үс уналтын эсрэг бүтээгдэхүүний туршилт судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл" төсөл хэрэгжүүлэх зорилгоор "Гарааны дерма лаб" ХХК-ийг Анагаах ухааны хүрээлэнгийн оролцоотойгоор 2016 онд үүсгэн байгуулсан. Уг компанийн дүрмээр Анагаах ухааны хүрээлэн эзэмшигчийн өмчийн 10 хувийг эзэмшдэг ба компанийн санхүүгийн тайлантай танилцахад тус компани 2017 онд орлого олоогүй, 14.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, 2018 онд 112.5 сая төгрөгийн орлого олж 83.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. 2017, 2018 онуудад тус компани алдагдалтай ажилласнаас ашиг хуваарилаагүй ба дараагийн жилүүдэд тус компанийн санхүүгийн тайланг авч үзэж ашиг хуваарилах боломжтой эсэх талаар судалж үзэх нь зүйтэй байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Анагаах ухааны хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1(нэг) хөтөлбөр, 2 (хоёр) арга хэмжээнд зориулан 2018 онд 677,611.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогыг 677,611.5 мянган төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэл 672,611.5 төгрөг буюу 99.3 хувь байгаа нь үндсэн үйл ажиллганы орлого болох 5,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөө тасарсантай холбоотой юм. Энэ нь орлогыг төлөвлөгөө үндэслэлгүй хийгдсэнээс төлөвлөгөө тасархад хүргэсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 668,820.3 мянган төгрөг буюу 98,7 хувьтай байгаа ба батлагдсан төсвийг нийт дүнгээрээ 11,208.8 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар хэмнэсэн байна. Төсвийн зардлын зүйл бүрээр авч үзвэл батлагдсан төсвөөс хэтэрсэн зардал байхгүй байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Анагаах ухааны хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад тус байгууллага нь өөрийн веб сайтандаа шилэн дансны /www.shilendans.gov.mn/ мэдээллийг бүрэн, хугацаанд нь оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 6-н зөвлөмж өгөгдсөнөөс 3 нь биелэж 3 нь хэрэгжээгүй буюу 50 хувьтай байна. Анагаах ухааны хүрээлэнгийн удирдлагын зүгээс өгсөн зөвлөмжийг биелүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн ба биелэгдээгүй зөвлөмжүүд нь тэд өөрсдөө шийдвэрлэх боломжгүй асуудал тул түүний биелэгдээгүй шалтгаан үр дагавар гаргасан шийдлийг доорх байдлаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Анагаах ухааны хүрээлэнгийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хэд хэдэн тайлант хугацаанд хамаарах эрдэм шинжилгээний зардал, түүнтэй холбоотой санхүүжилтийн орлогыг тухайн тайлант хугацаанд бүртгэж тайлагнах талаар нарийвчлан тусгаагүй тул уг асуудлыг удирдлагын зүгээс шийдвэрлэх боломжгүй байна.
2. Анагаах ухааны хүрээлэн төлбөртэй үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй, түрээсийн орлого оруулах өөрийн байргүй тул үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй байтал жил бүрийн төсөв дээд шатны байгууллагаас төсөвт

байгууллагын үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөгийг оруулахаар батлагдаж ирдэгээс уг орлогын төлөвлөгөө биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох дээд шатны байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын явцад авч үзэх.

3. 2018 онд Анагаах ухааны хүрээлэнгийн санхүүгийн тайланд бүртгэлтэй одоогоор ашиглаж байгаа байгаа нийт 30 нэр төрлийн 358,251.1 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгө нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд байгаа нь хөрөнгийн бодит үнэ цэнийг үнэн зөв илэрхийлээгүй байгаа тул хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, данс бүртгэлд тусгах талаар зөвлөмж хүргүүлсэн ч тайлант онд тэдгээр хөрөнгүүдийг холбогдох журмын дагуу дахин үнэлэх шаардлагагүй гэж үзсэн. Анагаах ухааны хүрээлэн нь Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-н 4.39-д “Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг ашиглалтаас хасахгүй тохиолдолд тухайн хөрөнгийг хуримтлагдсан элэгдлийнх нь хамт данснаас хасах хүртэл нь бүртгэлд хэвээр тусгана” гэж заасныг мөрдөж ажиллаж байна.

Шийдвэрлэсэн нь: Ирэх онд хэрэгжих төрийн өмчийн дахин үнэлгээний асуудлаар уг асуудлыг шийдвэрлүүлэх.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Анагаах ухааны хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тооллогын үр дүнгийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Анагаах ухааны хүрээлэн хагас бүтэн жилээр хийгдсэн хөрөнгийн тооллогын үр дүнг хүрээлэнгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хөрөнгийн ашиглалтын байдал цаашид ашиглах боломжтой хугацаа, тэг үлдэгдэлтэй хөрөнгийн талаар огт хэлэлцэж үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.3-т “агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг арилгах арга хэмжээ авах” 4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгийн ашиглалт, зарцуулалт хяналтыг сулруулж, улмаар хөрөнгийг зүй бусаар ашиглах, шамшигдуулах.

3.1.3 Зөвлөмж:

Тооллогын үр дүнг тус хүрээлэнгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хөрөнгийн ашиглалтын байдал цаашид ашиглах боломжтой хугацааны талаар

шийдвэр гаргаж ажиллах.

3.1.4 Төсвийн захирагчийн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,240,677.43	290,473,395.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	1,725.37	-
335	Бусад авлага	1,725.37	-
3351	Байгууллагаас авах авлага	1,725.37	-
34	УРЬДЧИЛГАА	122,038,952.06	266,833,567.78
34600	Урьдчилж гарсан зардал	122,038,952.06	266,833,567.78
35	БАРАА МАТЕРИАЛ	200,000.00	23,639,828.00
351	Түүхий эд материал	-	13,219,500.00
35110	Тусгай зориулалттай материал	-	11,533,500.00
35130	Эм боох материал	-	1,686,000.00
354	Хангамжийн материал	200,000.00	10,420,328.00
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	4,359,328.00
35420	Аж ахуйн материал	-	900,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	4,626,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	480,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	55,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	137,058,110.51	125,370,175.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	137,058,110.51	125,370,175.05
392	Биет хөрөнгө	136,596,110.43	122,874,674.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,050,000.00	33,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,020,750.23	-20,325,750.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	514,143,153.05	519,164,991.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-399,709,452.32	-413,072,301.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,906,477.00	20,906,477.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,523,317.07	-17,598,741.28
39217	Ном	750,000.00	750,000.00
393	Биет бус хөрөнгө	462,000.08	2,495,500.14
39301	Програм хангамж	770,000.00	3,270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-307,999.92	-774,499.86
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	259,298,787.94	415,843,570.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	121,771,42.34	550,421.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	121,771,142.34	550,421.67
413	Өглөг	1,142.34	550,421.67
	Ажилчидад өгөх өглөг	1,142.34	550,421.67
414	Урьдчилж орсон орлого	121,770,000.00	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	121,770,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	137,527,645.60	415,293,149.16
51	Засгийн газрын хувь оролцоо	137,527,645.60	415,293,149.16
511	Засгийн газрын оруулсан капитал	585,204,089.50	585,204,089.50
51101	Өмч: - төрийн	585,204,089.50	585,204,089.50
512	Хуримтлагдсан үр дүн	-472,263,749.48	-194,498,245.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-472,263,749.48	-472,263,749.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	277,765,503.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,587,305.58	24,587,305.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	259,298,787.94	415,843,570.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	512,895,100.00	827,786,580.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		121,770,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		121,770,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		121,770,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		121,770,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	512,895,100.00	706,016,580.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512,895,100.00	672,611,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	512,895,100.00	672,611,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		33,405,080.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	28,405,080.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт усгагдсан төсвөөс доод шатны төсвийн ахирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	521,396,933.01	550,021,076.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	518,792,149.50	546,216,080.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,792,149.50	546,216,080.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,822,464.82	417,255,664.00
210101	Үндсэн цалин	22,822,464.82	417,255,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,063,828.99	49,486,023.93
210201	Тэтгэврийн даатгал	46,063,828.99	34,137,993.93
210202	Тэтгэмжийн даатгал		4,134,032.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,261,146.00
210204	Ажилгүйдлийн даатгал		722,986.00
210205	Эрүүл мэндийн даатгал		7,229,866.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,846,700.00	8,808,179.00
210301	Гэрэл, цахилгаан	3,672,000.00	3,783,479.00
210302	Түлш, халаалт	3,374,700.00	3,374,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,554,000.00	7,983,082.10
210401	Бичиг хэрэг	1,204,000.00	194,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,984,082.10
210404	Ном, хэвлэл	100,000.00	4,755,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,650,000.00	50,000.00
2105	Нормативт зардал	550,000.00	40,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	40,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	9,996,600.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	9,996,600.00
2107	Томилот, зочны зардал	7,050,000.00	4,433,660.00
210702	Дотоод албан томилот	7,050,000.00	4,433,660.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,610,999.00	29,003,098.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,391,599.00	27,848,598.00

Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,994,156.69	19,209,773.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,939,156.69	19,209,773.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,604,783.51	3,804,995.95
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,604,783.51	3,804,995.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,604,783.51	3,804,995.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,501,833.01	277,765,503.56
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,501,833.01	277,765,503.56

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	610,588,981.00	706,016,580.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	610,588,981.00	706,016,580.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,543,881.00	
120	Нийтлэг татварын бус орлого	13,543,881.00	
120004	Дансны код	13,543,881.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,543,881.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,045,100.00	706,016,580.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	597,045,100.00	672,611,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	597,045,100.00	672,611,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,405,080.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	28,405,080.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	589,648,981.00	707,437,603.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589,648,981.00	707,437,603.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	574,444,197.49	703,632,607.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,049,194.64	424,212,534.33
210101	Үндсэн цалин	323,082,394.6	371,551,134.33
210102	Нэмэгдэл	66,397,200.00	36,601,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,569,600.00	11,955,100.00
210104	Урамшуулал	-	4,104,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,693,558.22	49,415,648.92
210201	Тэтгэврийн даатгал	29,119,287.95	35,594,070.92
210202	Тэтгэмжийн даатгал	4,143,567.59	3,823,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,314,854.05	3,059,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	828,713.52	764,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,287,135.11	6,174,078.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,846,700.00	8,808,179.00
210301	Гэрэл, цахилгаан	3,672,000.00	3,783,479.00
210302	Түлш, халаалт	3,374,700.00	3,374,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,750,000.00	8,534,082.10
210401	Бичиг хэрэг	700,000.00	300,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,984,082.10
210404	Ном, хэвлэл	100,000.00	5,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,350,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	550,000.00	544,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	544,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	9,996,600.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	9,996,600.00

2107	Томилолт, зочны зардал	7,050,000.00	4,433,660.00
210702	Дотоод албан томилолт	7,050,000.00	4,433,660.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,660,863.63	197,687,902.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,441,463.63	195,097,833.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,543,881.00	1,435,569.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,543,881.00	1,435,569.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,204,783.51	3,804,995.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,600,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,604,783.51	3,804,995.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,604,783.51	3,804,995.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,940,000.00	1,421,023.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,940,000.00	7,521,838.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,940,000.00	7,521,838.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,940,000.00	7,521,838.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,940,000.00	7,521,838.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-20,940,000.00	-7,521,838.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	-458,527,435.07	151,263,960.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	-458,527,435.07	151,263,960.01
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-5,234,481.40	-5,234,481.40
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	-472,263,749.48	137,527,645.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	-472,263,749.48	137,527,645.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	277,765,503.56	277,765,503.56
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,204,089.50	24,587,305.58	-194,080,022.57	415,843,570.83

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	677,611,500.00	668,820,305.65	-8,791,194.35	98.7
УРСГАЛ ЗАРДАЛ	677,611,500.00	668,820,305.65	-8,791,194.35	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	677,611,500.00	668,820,305.65	-8,791,194.35	98.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,483,900.00	416,705,242.33	-6,778,657.67	
Үндсэн цалин	370,822,500.00	364,043,842.33	-6,778,657.67	98.
Нэмэгдэл	36,601,900.00	36,601,900.00	-	100
Унаа хоолны хөнгөлөлт	11,955,100.00	11,955,100.00	-	00
Урамшуулал	4,104,400.00	4,104,400.00	-	100
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,937,900.00	49,415,648.92	-1,522,251.08	97
Тэтгэврийн даатгал	34,162,900.00	35,594,070.92	1,431,170.92	104.2
Тэтгэмжийн даатгал	4,193,800.00	3,823,600.00	-370,200.00	
ҮОМШӨ-ний даатгал	3,355,000.00	3,059,500.00	-295,500.00	91.2
Ажилгүйдлийн даатгал	838,700.00	764,400.00	-74,300.00	
Эрүүл мэндийн даатгал	8,387,500.00	6,174,078.00	-2,213,422.00	73.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,063,300.00	8,808,179.00	-255,121.00	
Гэрэл, цахилгаан	3,888,600.00	3,783,479.00	-105,121.00	97.3
Түлш, халаалт	3,374,700.00	3,374,700.00	-	
Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,650,000.00	-150,000.00	91.7
Хангамж, бараа материалын зардал	8,550,000.00	8,534,082.10	-15,917.90	99.8
Бичиг хэрэг	300,000.00	300,000.00	-	
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000,000.00	2,984,082.10	-15,917.90	
Ном, хэвлэл	5,100,000.00	5,100,000.00	-	100
Нормативт зардал	550,000.00	544,000.00	-6,000.00	
Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	544,000.00	6,000.00	98.9
Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,996,600.00	-3,400.00	
Урсгал засвар	10,000,000.00	9,996,600.00	-3,400.00	
Томилолт, зочны зардал	4,500,000.00	4,433,660.00	-66,340.00	98.5
Дотоод албан томилолт	4,500,000.00	4,433,660.00	-66,340.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,526,400.00	170,382,893.30	-143,506.70	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,342,000.00	169,228,393.30	-113,606.70	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	
Даатгалын үйлчилгээ	59,400.00	59,400.00	-	100
Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	70,100.00	-29,900.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00	-	100

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	677,611,500.00	672,611,500.00	-5,000,000.00	99.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	672,611,500.00	672,611,500.00	-	
Улсын төсвөөс санхүүжих	672,611,500.00	672,611,500.00	-	100
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	-	-5,000,000.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-	-5,000,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
Төсвийн байгууллага	1	1		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.00	46.00		
Удирдах ажилтан	1.00	1.00		100
Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00		
Үйлчлэх ажилтан	6.00	6.00		100

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	33,405,080.00	-33,405,080.00	-
УРСГАЛ ЗАРДАЛ	-	33,405,080.00	-33,405,080.00	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	33,391,278.40	-33,391,278.40	-
Төвлөрүүлэх илжүүлэг	-	13,801.60	- 13,801.60	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	33,405,080.00	-33,405,080.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,405,080.00	-33,405,080.00	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	28,405,080.00	-28,405,080.00	-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00	-5,000,000.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

5. Аудитын явцад илүүрлсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.19	Аудитын нэр: Анагаах ухааны хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/53/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр: Анагаах ухааны хүрээлэн	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл Нэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	1 дүгээр сараас 9 сар хүртэлх ажилчдын цалинг тооцож олгохдоо ажилласан цагийн тооцооны хүснэгтийг үндэслэж олгоогүй байна.	278,631.5	Албан шаардлага	Ерөнхий менежер Нягтлан бодогч	П.Эрхэмбулган, Б.Оюунжаргал
2	Анагаах ухааны хүрээлэн хагас бүтэн жилээр хийгдсэн хөрөнгийн тооллогын үр дүнг хүрээлэнгийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хөрөнгийн ашиглалтын байдал цаашид ашиглах боломжтой хугацаа, тэг үлдэгдэлтэй хөрөнгийн талаар огт хэлэлцэж үнэлэлт дүгнэлт гаргаагүй байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий менежер Нягтлан бодогч	П.Эрхэмбулган, Б.Оюунжаргал
	Дүн	278,631.5			